

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН  
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

---

Улаанбаатар хот  
2021 он

## **ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу тооцлоо.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцохын зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд оногдох зардал байгаа эсэхэд тооцож үзэв.

### **1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгийн эдийн засгийн чиглэлд "Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. ..." гэж заасан ба Зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, галт хэрэглэлийг гаалийн тариф, гаалийн татвараас чөлөөлөхтэй холбогдон эрх зүйн зохицуулалтыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бий болгосноор иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй болно.

### **2. Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо хуулийн төсөлд тусгагдсан зардал гарах агуулга бүхий заалтыг тодорхойлж, улмаар зардал гарах талаар судалж үзэв.

Манай улсын хувьд батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн 90 гаруй хувийг ОХУ-ын бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эдгээрийн ихэнх хувийг сүүлийн 20 гаран жилийн хугацаанд буцалтгүй тусламжаар нийлүүлсэн байдаг.

Батлан хамгаалах яам нь дэлхийн 36 улстай цэргийн дипломат харилцааг тогтоож, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна. Үүнээс ОХУ, БНХАУ, БНТУ, Украин Улс, Белерусь Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдыг сургаж, бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тухайлбал; 2016-2020 оны хооронд ОХУ-аас 166,0 тэрбум төгрөгийн үнэ бүхий Т-72 танкийн хавчуурга гол төмөр, нисэх буудлын газрын үйлчилгээний техник, тоног

төхөөрөмж, сургууль-байлдааны сөнөөгч онгоц, БНХАУ-аас 3, 4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүн тээврийн автобус, инженерийн техник, "Ковид-19" цар тахлын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, АНУ-аас 34,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий инженерийн техникүүд, хөнгөн хуягласан автомашин, компьютер, англи хэлний сурах бичиг, хээрийн II шатны эмнэлэг, ХБНГУ-аас 5,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий шатахуун тээвэрлэгч, техникийн засвар-үйлчилгээний байр, зөөврийн амьсгалын аппарат, Ковид-19 цар тахлын халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус хүлээн авсан. Үүний зэрэгцээ Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, сургалт бэлтгэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор худалдааны гэрээгээр 2018 онд ОХУ-аас 96,190.60 ам.долларын үнэ бүхий 7,62 мм сум 253,000 ширхэгийг, 2019 онд 13,234,000.00 рублийн үнэ бүхий нисдэг тэрэгний сүүлний сэнс 2 ижийг, 63,000.00 еврогийн үнэ бүхий Т-72 танкийн тусгай зориулалтын 6СТ-140N загварын 252 ширхэг тус тус худалдан авсан бөгөөд "Гаалийн тариф, татварын тухай хууль"-д зохицуулалт байхгүйн улмаас 114,341,746.00 төгрөгийн гаалийн татвар ногдож, үүнээс 62 сая орчим төгрөгийн төлөлтийг хийсэн.

Цаашид БНХАУ-аас нийт 70 сая буюу 30.4 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, ОХУ-аас худалдааны гэрээгээр 1,7 сая ам.долларын үнэ бүхий нисдэг тэрэг, 2,2 сая еврогийн үнэ бүхий радиолокацийн станц, БНЧУ-аас 5, 8 тэрбум төгрөгийн үнэ бүхий сум, галт хэрэглэлийг худалдан авахаар гэрээ байгуулсан боловч 5,1 тэрбум төгрөгийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх нөхцөл байдал үүсэхээр байна.

Улсын эдийн засгийн байдал, төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүдэж гадаад улсын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гаднаас оруулж ирж байгаа цэргийн зэвсэглэл, тусгай техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгслийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх төлбөрийн хүндрэлтэй асуудал жил болгон бидний өмнө тулгарч байна. Энэ нь шууд төсөв хөрөнгөтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд гадаадын улс, орнуудаас үзүүлж буй тусламжууд цаг хугацааны хувьд хэзээ хэрэгжих нь тодорхой бус байдаг бөгөөд тухайн хандивлагч улсаас шууд хамааралтай тул батлан хамгаалах төсөвт тусламжийн бараа материалыг хүлээн авахад төлөгддөг гааль, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татварын зардлыг тусгах боломжгүй юм. 2020-2024 онд буцалтгүй тусламж болон худалдааны гэрээгээр доорх зэвсэглэл, техник, бараа материалыг хүлээн авахаар төлөвлөж байгаа ба хуулийн зохицуулалтаас хамаарч ногдох татвар хураамжийг тооцсон болно. Үүнд:

№	Хүлээн авах буцалтгүй тусламж болон худалдааны гэрээ	Гэрээний дүн	Хуулиар ногдох татвар, хураамж	
			НАӨТ-10% /төгрөг/	Гааль-5.5 % /төгрөг/
1	БНХАУ-аас үзүүлэх буцалтгүй тусламж /Арматур, автобус, гал тогооны тоног төхөөрөмж/	70 сая юань	7,000,000.00 юань төлөх	хуулийн 38.1.2
2	ОХУ-аас Ми-8Т загварын 1 нэгж нисдэг тэрэг	1,780,000.0 ам.доллар	Хуулийн 13.1.5	178,000.00 ам.доллар

	худалдан авах			төлөх
3	БНЧУ-аас П-18 радиолокацийн станцыг худалдан авах	2,210,000.0 евро	Хуулийн 13.1.5	221,000.00 евро төлөх
4	БНЧУ-аас Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багт шаардлагатай галт хэрэглэлийг худалдан авах	5,800,000,000.0 төгрөг	580,000,000.00 төгрөг төлөх	319,000,000.00 төгрөг төлөх
<b>Татвар төлөх нийт дүн</b>			3,612,610,000.00	1,572,708,990.00
<b>Бүгд</b>			5,185,318,990.00	

/Тайлбар: Монгол банкны 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн ханшаар ам.долларыг 2,848.94 төгрөгөөр, еврог 3,378.27 төгрөгөөр, юанийг 433.23 төгрөгөөр тус тус тооцов./

Улс орныг батлан хамгаалах чиглэлээр импортоор оруулж ирж байгаа зэвсэглэл, тусгай техник хэрэгсэл, хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, галт хэрэглэл, сэлбэг, тоног төхөөрөмж, хэрэгсэлд төлөх гаалийн татвараас чөлөөлснөөр батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны бэлэн байдал, орчин үеийн цэргийн зэвсэглэл, тусгай техник, тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн хангагдсан, хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх чадавхи нэмэгдсэн, төсвийн үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулалт бий болох боломж бүрдэх юм.

Мөн дээр дурдсан боломжуудаас гадна Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний талаар баримтлах бодлого, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болохын зэрэгцээ Зэвсэгт хүчний өмнө тулгамдаж байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэл хэрэгжих, сургалт бэлтгэлийн түвшин дээшлэх, давуу талууд үүсэх бөгөөд улсын төсөвт нэмэлт зардал гарах зохицуулалтыг хуулийн төсөлд агуулаагүй тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд холбогдох зохицуулалтыг тусгаснаар улсын төсөвт шинээр зардал бий болохгүй болно.